



ЭРҮҮЛ МЭНДИЙГ
ЦЭНЭГЛЭСЭН 10 ЖИЛ

2021
ЖИЛИЙН ТАЙЛАН

АГУУЛГА

ТУЗ-ИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ.....	2
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ.....	3
ТҮҮХЭН ТОВЧОО.....	4
2021 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ, НИЙГЭМД ҮЗҮҮЛСЭН ЭЕРЭГ НӨЛӨӨ.....	6
2021 ОНЫ ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД.....	9
ҮЙЛДВЭР, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАНИЛЦУУЛГА.....	12
2021 ОНД ШИНЭЭР ГАРГАСАН БҮТЭЭГДЭХҮҮНҮҮД.....	17
КОМПАНИЙН СОЁЛ, ХҮНИЙ НӨӨЦИЙН ӨСӨЛТ ХӨГЖИЛ.....	19
ХЭТИЙН ЗОРИЛГО.....	21
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН МФС 2.0 ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА.....	22





ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм хэрэглэгч, итгэлтэй харилцагч, Монгол оюун сэтгэлгээнд хөрөнгө оруулагч хувьцаа эзэмшигчид та бүхнийхээ амар амгаланг айлтган мэндчилж байна.

Монос групп 1990 онд Монгол Улсын эдийн засгийн хүндхэн цаг үед анх бизнесийн гараагаа эхлүүлж байсан нь аливаа сорилтыг хамтын хүчээр даван туулах амжилтын үндэс суурь болсон байдаг.

Үүнээс улбаалан өнөөдөр Монос группийн хэмжээнд 30 гаруй салбар компани үйл ажиллагаагаа явуулж байгаагаас олон нийтэд нээлттэй “Монос Хүнс” ХК-ийнхаа 2021 оны үйл ажиллагааны үр дүнг тайлагнах цаг иржээ.

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын нөлөөгөөр Монгол улсын бизнесийн орчин нэлээдгүй сорилт, бэрхшээлүүдтэй нүүр тулсан ч “Монос Хүнс” ХК-ийн хамт олны маань хичээл зүтгэлийн үндсэн дээр 2021 оныг чамгүй ололт, амжилттай үдсэнийг дуулгахад таатай байна.

Ард иргэдээ хүнсээр нь дамжуулан эрүүлжүүлэх, аливаа өвчлөлөөс урьдчилан сэргийлэх эрүүл чанартай хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор “Монос Хүнс” ХК-ийг 2012 онд байгуулж байсан нь өдгөө 10 жил ойн босгон дээрээ иржээ.

Өнгөрөгч 10 жилийн хугацаанд үйлдвэрлэн гаргасан эрүүл мэндийг дэмжих үйлдэлтэй хуурай болон шингэн хүнсний бүтээгдэхүүн нь хэрэглэгчдийн өдөр тутмын хэрэглээ болж, үүнийг дагаад үйлдвэрлэл болон борлуулалтын орлого жил бүр тогтмол **40** гаруй хувиар өсч, салбартаа тэргүүлэгч үндэсний үйлдвэрлэгч, олон нийтэд нээлттэй хувьцаат компани болон өргөжөөд байна.

Энэ бүх ололт амжилт нь бид бүхний шинэ санал санаачилгаар олон жилийн судалгаа шинжилгээнд суурилсан эрүүл, чанартай бүтээгдэхүүн, ард иргэдийн өмнө хүлээсэн ёс зүйн хэм хэмжээг баримтлан ажилладаг мэдлэг чадвартай хамт олны нөр их хөдөлмөрийн үр шимээр бий болсон билээ.

Бид бүхний энэ хичээл зүтгэлийг үргэлж дэмжин эрүүл, чанартай бүтээгдэхүүнийг сонгон хэрэглэдэг эрхэм хэрэглэгчид, итгэл хүлээлгэн хамтран ажилладаг итгэлтэй харилцагч, Монгол оюун сэтгэлгээнд хөрөнгө оруулагч нийт хувьцаа эзэмшигч та бүхэндээ чин сэтгэлээсээ талархаж буйгаа илэрхийлэхийн ялдамд цаашид олон арван ололт амжилтыг хамтдаа бүтээхийн ерөөл дэвшүүлье.

Хувьцаат компани байгуулах хүсэл их эрт төрсөн юм. Компани маань бага багаар хөгжиж, өсөж дэвжихийн хэрээр энэ бодол намайг улам л эзэмдэх болсон билээ. Олны амьдрал хэцүү байхад зарим нэг нь өсч дэвжээд хөрөнгө мөнгөтэй болж ялгараад яахав, хамтдаа зүтгэж, хамтдаа бүтээж, хамтдаа хөгжье, хамтдаа баяжъя гэж бодсон юм.

“Бүтээлч Моносчууд бүгдийг тэгээс”
НОМНЫ ХЭСГЭЭС

Л.Хүрэлбаатар
Монгол Улсын Хөдөлмөрийн Баатар, Академич,
Монос Хүнс ХК-ийн ТУЗ-ийн дарга



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Эрүүл чанартай хүнсний бүтээгдэхүүнийг өдөр тутмын хэрэгцээнд нийцүүлэх үйлсэд итгэл хүлээлгэн бидэнтэй хамт байдаг эрхэм хэрэглэгч, итгэлтэй харилцагч, хөрөнгө оруулагчид та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Өнгөрөгч 2021 он дэлхий нийтээрээ цар тахлын хүндхэн сорилтой нүүр тулсан, Монгол Улсын эдийн засаг, гадаад худалдаа, тээвэр ложистикийн тогтворгүй, тааварлашгүй нөхцөл байдалд хурдтай шийдвэр гаргалтаар үйл ажиллагаагаа тогтвортой авч явах, ажлын байраа хадгалах, олон сорилттой тулгарсан ч бид дотоодын эрүүл мэндийн хүнсний зах зээлийг хөгжүүлэх, хэрэглэгчдийг чанартай бүтээгдэхүүнээр тасралтгүй хангах, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг өсгөх үүргээ амжилттай биелүүлж чадлаа.

Энэ онд Монос Хүнс ХК-ийн 10 жилийн ойн тохиож байгаа нь өнгөрсөн хугацааны ололт амжилт, үйл ажиллагааны үр дүнгээ дүгнэх мөн цаашдын зорилго зорилтоо шинэчлэн тодорхойлох цаг ирснийг илтгэж буй.

Үйлдвэрлэлийн салбарт 10 жил гэдэг харьцангуй богинохон хугацаа боловч бид бүхэн эрүүл мэндийн салбартаа тэргүүлэх хуурай болон шингэн хүнсний үйлдвэрийн 70 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнийг зах зээлд амжилттай байршуулж, 250 гаруй ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Өнгөрсөн оны хувьд борлуулалтын орлогоо 50 гаруй хувь, цэвэр ашгаа 2 дахин өсгөж улсын төсөвт 1.1 тэрбум төгрөгийн татварыг төлжээ. Мөн хувьцааны ханшаа 2 дахин нэмэгдүүлсэн зэрэг чамгүй ололт амжилттайгаар ийнхүү ойн босгон дээрээ ирлээ.

Бид хэрэглэгчдийн сэтгэл ханамж, чанар стандартыг үргэлж 1 номерт тавьдаг бөгөөд олон улсын стандартуудыг хангах зорилгоор нэвтрүүлсэн Чанарын удирдлагын тогтолцоо **ISO 9001:2015**, Хүнсний үйлдвэрлэлийн хяналтын тогтолцоо **HACCP** стандартуудаа баталгаажуулснаас гадна хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо **FSSC 22000**, байгаль орчны удирдлагын тогтолцоо **14001**, лабораторийн баталгаажилтын **17025**, хүний нөөцийн удирдлагын **30400** стандартуудыг тус тус үйл ажиллагаандаа нэвтрүүлж эхэллээ.

Ирэх он жилүүдэд Монгол оюун санаанд түшиглэн эрүүл мэндийг дэмжих үйлдэлтэй бүтээгдэхүүнийхээ чанарыг улам сайжруулан, нэр төрлийг нь олшруулж ард иргэддээ хүргэхээс гадна компанийн цаашдын хөгжлийг тасралтгүй үргэлжлүүлэх экспортын шинэ боломжуудыг эрэлхийлэн хөгжиж буй орнуудын онцлог хэв маягт нийцсэн бүтээгдэхүүнийг судалгаа шинжилгээнд үндэслэн хөгжүүлэх, хоёрт талт ашигт ажиллагааны түншлэлийг бий болгохоор ажиллаж байна.

Олон улсын техник болон технологийн дэвшил, ололт амжилттай нээлтүүд амьдралын шинэ, энгийн байдлын хэв маягт нийцэж, өвдөхөөс урьдчилан сэргийлэх бүтээгдэхүүнийг туршлагатай дотоодын болон олон улсын эрдэмтэд, хүнсний технологичдийн мэдлэгт тулгуурлан хөгжүүлэх, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлж, улмаар экспортын боломжийг эрэлхийлэн тогтвортой өсөлтийг ханган ажиллахыг зорьж байна.

Монос Хүнс ХК-ийн бүтээгдэхүүнийг таалан хүртдэг эрхэм хэрэглэгчид, итгэл хүлээлгэн хамтран ажилладаг хувьцаа эзэмшигчдэдээ, амжилтын түүхийг хамтдаа бүтээж буй хамт олныхоо нэрийн өмнөөс чин сэтгэлийн талархал илэрхийлье.

А.Отгондарь
Монос Хүнс ХК-ийн Гүйцэтгэх захирал

Түүхэн товчоо

2012



"Монос Фарм" ХХК-аас өрх тусгаарлаж, "Монос Хүнс" ХХК албан ёсоор үүсгэн байгуулагдав.

2013



Шилэн савлагаатай Цэнэг эрүүл мэндийн бэлдмэлийг үйлдвэрлэлд нэвтрүүлэв.

2014



ODOO ERP /Enterprise Resource Planing/ системийг компанийн үйл ажиллагаанд нэвтрүүлэв.

2015



Монгол Улсад анх удаа Экос pH8.5 зөөлөн шүлтлэг усыг үйлдвэрлэв.

2016



Монгол Улсад анх удаа Эко уусдаг цайг үйлдвэрлэж эхлэв.

2017



Чанарын удирдлагын тогтолцоо болох ISO9001:2015 болон Хүнсний үйлдвэрлэлийн хяналтын тогтолцоо HACCP стандартыг нэвтрүүлэх төслийн ажил эхлэв.



2018



БНХАУ болон Япон улсын зах зээлд бүтээгдэхүүнээ байршуулснаар албан ёсоор экспортын гараагаа эхлүүлээ.



2019

Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан IPO гаргаж нээлттэй Хувьцаат Компани болов. Олон улсын чанарын удирдлагын тогтолцоо **ISO9001:2015** болон Хүнсний үйлдвэрлэлийн хяналтын тогтолцоо **HACCP** стандартуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж Олон улсын аудитын **SGS** компаниар баталгаажуулж гэрчилгээгээ гардан авав.

2020

Хүнсний үйлдвэрийн нэгдсэн удирдлагын тогтолцоо **ISO22000:2018** болон Хүний нөөцийн менежментийн **ISO:30400** стандартыг нэвтрүүлэх төслийг эхлүүлэв.

Эрүүл Мэндийн Шингэн хүнсний үйлдвэрийг ашиглалтад оруулан, 8 нэр төрлийн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэв.



VITOS
more health



2021

Vitos брэндийн Цэнэг эрүүл мэндийн бэлдмэлийг шинэчлэн зах зээлд амжилттай байршуулав. Мөн тус брэндийн "Shot" 3 нэр төрлийн биологийн идэвхт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн гаргалаа.

2021 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ эрүүл мэндийн төвтэй хамтын ажиллагааны санамж бичиг байгууллаа.

Монос Хүнс ХК-ийн чухал зорилтуудын нэг нь "Үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааг хангасан хамт олон" байх бөгөөд энэхүү зорилтын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвтэй хамтын ажиллагаа өргөжүүлэх санамж бичгийг байгуулж цаашид хамтран ажиллахаар боллоо.



Монос Хүнс ХК нийт ажилтнуудгаа хувийн тэтгэврийн хуримтлал үүсгэлээ

Бид хэрэглэгчиддээ эрүүл мэндэд нь ашиг тустай бүтээгдэхүүн хүргэх, түүгээрээ дамжуулан эрүүл мэндийн боловсрол олгох нийгмийн хариуцлагыг өмнөө тавин ажилладаг. Харин энэхүү зорилгыг биелүүлэгч гол хөдөлгүүр буюу манай компанийн үнэт зүйл болох нийт ажилтан, албан хаагчид маань юм. Мөн тус компанийн нийт ажилтны дундаж нас 35 бөгөөд улс орны хөгжлийн эзэд болсон залуучууддаа тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлж ирээдүйд нь итгэл, урт хугацааны санхүүгийн баталгааг бий болгох үүднээс АРД ЛАЙФ ХХК-ийн хувийн тэтгэврийн хуримтлалд хамруулж гэрээгээ үзэглэлээ.



Эрүүл мэндийн боловсролыг дэмжих "Healthy Life" подкаст

Эрүүл мэндийг дэмжигч Монос Хүнс ХК ард иргэдийнхээ эрүүл мэндийн боловсролыг дэмжих, тухайн цаг үед тулгамдаж буй өвчлөл, асуудлуудыг хэрхэн даван туулах арга зам, мэдлэгийг олгох "Healthy Life" эрүүл мэндийн зөвлөгөө подкаст контентийг бэлтгэн хүргээд байна.



Байгальд ээлтэй үйлдвэрлэл

Бүтээгдэхүүний сав баглаа боодолдоо хог хаягдлыг ангилан хаях олон улсын стандартыг нэвтрүүлж хялбар таслах шугамыг бүтээгдэхүүний шошгондоо 2019 оноос хойш ашиглаж байна. Ингэснээр иргэдэд хогоо ангилан хаях боломжийг бүрдүүлэв.

Цахилгаан:

Үйлдвэрийн хэмжээнд байгальд ээлтэй, эрчим хүч бага зарцуулдаг LED гэрэлтүүлэг, эрчим хүчний хэмнэлт бүхий А+ ангиллын цахилгаан хэрэгслүүдийг ашигласнаар 14-20%-ийн цахилгааны хэмнэлт хийдэг.



Ус:

Усны хэрэглээг багасгах, зөв зохистой хэрэглээ бий болгох үүднээс үйлдвэрлэлээс гарсан саарал усыг өөрсдийн ахуй хэрэглэндээ тогтмол ашиглаж, зарим тохиолдолд үйлдвэрийн орчины ногоон байгууламжийн усалгаанд ашиглаж байна.




НИЙГЭМД ҮЗҮҮЛСЭН ЭЭРЭГ НӨЛӨӨ

Rokit Bay ft. Anouca – ХЯЗГААРГҮЙ

Powered by Vitos Tseneg

"Vitos" Цэнэг брэндийн хамтран ажилласан. Rokit Bay ft. Anouca – ХЯЗГААРГҮЙ уран бүтээл нь аав, ээж байх хүндтэй үүрэг хариуцлага, гэр бүлийн халуун дулаан уур амьсгал цаашлаад эрүүл мэндэдээ анхаарах нь хамгийн чухал гэдгийг өгүүлсэн бүтээл болсон бөгөөд өнөөдрийн байдлаар YOUTUBE дээрх үзэлт нь 10 сая хүрээд байна.



"Guys" хамтлагийн дуучин М.Мягмар "ЭЭРЭГ ЦЭНЭГ"

Powered by Vitos Цэнэг

Мөн "Guys" хамтлагийн дуучин М.Мягмарын бие даасан шинэ уран бүтээл "ЭЭРЭГ ЦЭНЭГ" дуун дээр хамтран ажиллаа. Энэхүү уран бүтээл нь залуусаа аливаад цөхрөлгүй асуудлыг шийдвэрлэж, хүсэл мөрөөдлөөрөө сэрүүлэг хийж, зорисон зорилгоо биелүүлэхэд эрүүл мэнд хамгийн чухал гэх ойлголтыг өгсөн уран бүтээл болсон юм.

Өгөр тутамдаа эрүүл мэндгээ анхаарч хэзээ ч хаана ч хийх боломжтой "Workout in nature" гасгалын контент

Powered by Экос эрүүл амьдралын ус

Орчин үеийн техникийн дэвшилтэд технологи, автомат төхөөрөмжийн хурдацтай хөгжлийн энэ үед хөдөлгөөний дутагдал нь өнөө үеийн хүний биед аюултай өвчлөлийн тоонд дээгүүр бичигдэж эхлээд байна. Тиймээс 14 удаагийн цуврал бүтэн биеийн буюу хэзээ ч, хаана ч хийхэд тохиромжтой дасгалын контентыг бэлтгэн хүргэлээ.



НАС БОЛ ЕРДӨӨ ДЭЛХИЙ ТАНД
ТААЛАГДСАН ХЭДЭН ЖИЛИЙН 1 ТОО.

ЭРҮҮЛ + БАЙГААРАЙ

Бидний туулж буй нас бүр өөрийн гэсэн мөн чанар, утга учрыг бидэнд мэдрүүлж байдаг. Та мөрөөдлөө сэтгэлдээ багтааж, тууштай байснаар бодит болгож чадах юм. Тийм учраас бид бүхэн Ахмадын баярыг угтан сурахад, мөрөөдөхөд, хүссэнээрээ амьдархад нас бол ердөө тоо. Энэ бүх сайхан зүйлийг мэдрэхийн тулд хамгийн чухал нь өөрийгөө хайрлаж эрүүл мэнддээ анхаарч "ЭРҮҮЛ БАЙГААРАЙ" зорилготой нийгэмд чиглэсэн цуврал контентыг хийж гүйцэтгэлээ.

НИЙГЭМД ҮЗҮҮЛСЭН ЭЭРЭГ НӨЛӨӨ

МОНГОЛ ОЮУН САНААГ ДЭМЖСЭН ХАМТЫН АЖИЛЛАГАА



Оюуныг тэтгэж жаргал бэлэглэнэ уриатай Монгол телевизийн ээлжит Дэлхийн шилдэг телевизийн контент болох бүжгийн ертөнцийн гайхамшиг, гоо зүйг мэдрүүлэх "Ододтой бүжиглээ" шоу нэвтрүүлэгтэй Монос Хүнс компанийн Экос брэнд хамтран ажиллаа.

Mongol Content

Монос Хүнс ХК болон Монгол контент компанийн МААМУУ контент 5 дахь жилдээ хамтран ажиллаж байна. Тус төслийн хүрээнд хүүхэд багачуудын дуртай амин дэмээр баялаг 3 нэр төрлийн үрэл болон 4 төрлийн амтат шүүсээ хүүхэд багачууддаа зориулан үйлдвэрлэн гаргасаар байна.




ХАНДГАЙ ТАЙЛАГЧ

Монголын бүтээлч салбарт үнэтэй хувь нэмэр оруулж, Монголын соёлыг дэлхийд таниулах зорилготой ЭКОНТЭ ХХК-ийн Хандгай төсөлтэй Монос Хүнс ХК хамтран ажиллаж согтууруулах ундаанаас үүдэлтэй хордлогоос сэргийлж, шар тайлах үйлчилгээтэй, орчин цагийн "догь" залуусын хэрэглээ "ТАЙЛАГЧ" цоо шинэ бүтээгдэхүүнийг худалдаанд гаргалаа. Энэхүү бүтээгдэхүүний худалдан авалт бүр Монголын бүтээлч салбарт хувь нэмэр оруулах болно.

2021 ОНЫ ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД:


Борлуулалтын орлого

/сая.төг/




Нийт ашиг

/сая.төг/




Цэвэр ашиг

/сая.төг/




EBITDA


/сая.төг/




Нийт ашгийн маржин



Цэвэр ашгийн маржин



EBITDA маржин



САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

Үзүүлэлт /сая.төг/	2020	2021
	<i>Аудитлагдсан</i>	<i>Аудитлагдсан</i>
ХӨРӨНГӨ	19,191.1	22,996.0
Эргэлтийн хөрөнгө	5,954.7	9,818.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	58.1	258.0
Дансны авлага	2,529.7	2,880.0
Татвар, НДШ – ийн авлага	38.3	73.1
Бусад авлага	35.8	49.7
Бараа материал	2,448.2	5,785.6
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	844.6	771.5
Эргэлтийн бус хөрөнгө	13,236.4	13,178.0
Үндсэн хөрөнгө	13,063.8	12,639.3
Биет бус хөрөнгө	89.0	453.0
Хойшлогдсон татварын хөрөнгө	35.7	55.1
Бусад эргэлтийн бус хөрөнгө	47.8	30.6
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	19,191.1	22,996.0
Өр төлбөр	5,902.2	8,075.0
Богино хугацаат өр төлбөр	3,240.3	4,651.3
Дансны өглөг	664.4	798.4
Цалингийн өглөг	57.5	56.1
Татварын өр	553.9	509.0
НДШ - ийн өглөг	39.1	16.3
Банкны богино хугацаат зээл	1,464.2	2,676.1
Хүүний өглөг	78.5	20.8
Ногдол ашгийн өглөг	0.0	0.0
Урьдчилж орсон орлого	5.4	27.8
Бусад богино хугацаат өр төлбөр	377.4	393.1
Урт хугацаат өр төлбөр	2,661.8	3,423.7
Урт хугацаат зээл	2,650.2	3,294.1
Бусад урт хугацаат өр төлбөр	11.7	129.6
Эздийн өмч	13,288.9	14,921.0
Өмч	2,318.2	2,318.2
Нэмж төлөгдсөн капитал	6,835.7	6,835.7
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	616.1	451.9
Хуримтлагдсан ашиг	3,518.9	5,315.2

ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Үзүүлэлт /сая.төг/	2020	2021
Борлуулалтын орлого (цэвэр)	12,491.1	18,840.8
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	6,932.6	10,291.6
Нийт ашиг (алдагдал)	5,558.6	8,549.2
Түрээсийн орлого	2.4	5.7
Хүүний орлого	3.4	0.0
Бусад орлого	218.3	76.7
Борлуулалт, маркетингийн зардал	2,803.1	3,649.7
Ерөнхий ба удирдлагын зардал	1,191.0	1,586.7
Санхүүгийн зардал	321.6	616.8
Бусад зардал	137.2	398.6
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-36.2	-52.6
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-123.1	0.5
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	1,170.3	2,327.7
Орлогын албан татвар	160.1	298.0
Татварын дараах ашиг (алдагдал)	1,010.2	2,029.7

Санхүүгийн харьцаанууг

Үзүүлэлт	2020	2021
Төлбөрийн чадварын шинжилгээ / Liquidity Ratios		
Эргэлтийн харьцаа / Current Ratio	1.8	2.1
Түргэн хөрвөх харьцаа / Quick Ratio	1.1	0.9
Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээ / Leverage Ratios		
Бие даалтын коэффициент / Shareholder Equity ratio	69%	65%
Өрийн харьцаа / Debt ratio	31%	35%
Өр эзний өмчийн харьцаа / Debt-to-Equity	0.44	0.54
Хөшүүргийн харьцаа/ Debt-to-EBITDA	1.71	1.43
Ашигт ажиллагааны шинжилгээ / Profitability ratios		
Нийт ашгийн хувь / Gross profit margin	45%	45%
ХТЭХӨАшгийн хувь / EBITDA margin	19%	22%
Цэвэр ашгийн хувь / Net income margin	8%	11%
Нийт хөрөнгийн өгөөж / Return on Assets	5%	9%
Өөрийн хөрөнгийн өгөөж / Return on Equity-ROE	8%	14%

ШИНГЭН ХҮНСНИЙ ҮЙЛДВЭР

Эрүүл мэндийн шингэн хүнсний үйлдвэр нь Олон улсын чанарын удирдлагын тогтолцоо ISO9001:2015, аюулгүй байдлыг хангах HACCP стандартыг нэвтрүүлэн баталгаажуулсан, бүрэн автомат гэдгээрээ онцлогтой юм. Тус үйлдвэрт PET буюу хуванцар, SHOT буюу хуруу шилэн, POUCH буюу уутан савлагаатай эрүүл мэндийн ус ундаа, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн, зах зээлд нийлүүлж байна.



Нэг цагт
6,000 ширхэг

PET



Нэг цагт
3,000 ширхэг

Vial



Нэг цагт
4,500 ширхэг

SPOUT POUCH



ЭРҮҮЛ БАЙХ АМАРХАН

Элэг
хамгаалах
бэлдмэл



Алтангагнуурын
бэлдмэл



Гоо сайхны
бэлдмэл



Дархлаа
сайжруулах
бэлдмэл



ЭРҮҮЛ МЭНДЭЭ ЦЭНЭГЛЭ

Бөөр
хамгаалах
бэлдмэл



Барагшуны
бэлдмэл



SHOT ЭРҮҮЛ БИЕЙН ТӨЛӨӨ

Хар
саримс



Бөөр
хамгаалагч



Барагшун
Алтангагнуур



ЭКОС

ЭРҮҮЛ
АМЬДРАЛЫН УС

PH 8.5



SPARKLING



Аами & Таами



ХУУРАЙ ХҮНСНИЙ ҮЙЛДВЭР

Хуурай хүнсний үйлдвэрт байгалийн зэрлэг жимстэй ҮРЛЭН ЧИХЭР, ОРГАНИК УРГАМЛЫН ЦАЙ, ЖИМСТЭЙ УУСДАГ ЦАЙ зэрэг бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэн гаргаж байна.

Бид үйлдвэртээ GMP стандарт буюу үйлдвэрлэлийн зохистой дадлыг мөрдлөг болгон ажилладаг тул бүтээгдэхүүний орц, гарцын урсгал оновчтой төлөвлөгдсөн юм. Мөн ажилчдын хөдөлмөр хамгаалал болон хүнсний аюулгүй байдал бүрэн хангагдсан нөхцөлд эрүүл, чанартай бүтээгдэхүүний маань үйлдвэрлэл тасралтгүй үргэлжилдэг.



Эмийн ургамалтай ЭРҮҮЛ МЭНДИЙН ЦАЙ



ЭКО
УУСДАГ ЦАЙ

АЯГАНД
УРГАСАН ЖИМС



АЗ ЖАРГАЛЫН АМТТАЙ



Ааруултай
үрэл



Үзэмтэй үрэл



Витаминтай үрэл

ЖИМСЭЙ ШАХМАЛ ААРУУЛ
ТУГАЛ





TASTEА ЦАГААН ГААНЫ ТАСАРХАЙ АМТ

Цагаан гаа, зөгийн бал, нимбэг, турмерик



100 наслаарай

Монгол цай

АНТИОКСИДАНТААР
БАЯЛАГ

Увдист

БАЙГАЛЬ ЭХИЙН АНАГААХ УВДИСЫГ
ХЭРЭГЛЭГЧ ТАНЫ ХЭРЭГЦЭЭНД НИЙЦҮҮЛНЭ



Өтгөрүүлсэн
барагшун



Чацарганын
цэвэр тос



Чацарганын
үр хальсны
хандалмал тос

2021 ОНД ШИНЭЭР ГАРСАН БОЛОН ШИНЭЧЛЭГДСЭН БҮТЭЭГДЭХҮҮНҮҮД



VITOS SHOT брэндийн биологийн идэвхт 3 нэр төрлийн бүтээгдэхүүнийг зах зээлд шинээр гаргав

Монос Хүнс ХК-ийн "Vitos" брэндийн "Shot" 3 нэр төрлийн биологийн идэвхт бүтээгдэхүүнийг Эм судлалын хүрээлэнгийн эрдэмтдийн зургаан жилийн судалгааны үр дүнд үндэслэн биологийн идэвхт түүхий эд болох барагшун, хар саримс, эмийн үнэт түүхий эд болох алтангагнуур, өндөр зоосон цэцэг, нарийн навчит цахилдаг, тэхийн шээг, чихэр өвсний фармакологийн идэвхт нэгдлийн зохистой харьцаа, нийлэмж, боловсруулах технологид тулгуурлан, шууд хэрэглэхэд хялбар бүтээгдэхүүн болгон хэрэглэгч танд хүргэж байна. "Vitos Shot" брэнд нь барагшун алтангагнууртай, бөөр хамгаалагч, хар саримстай гэсэн төрлүүдтэй юм.

БӨӨР ХАМГААЛАГЧ

БИОЛОГИЙН ИДЭВХТ БҮТЭЭГДЭХҮҮН

Нарийн навчит цахилдаг



Бөөрний үйл ажиллагааг дэмжин кератинин мочевины хэмжээг бууруулах, бөөрний үрэвсэлт өвчнөөс урьдчилан сэргийлэх үйлдэлтэй.



Тэхийн шээг

Бөөрний тамирыг дэмжих, үрэвсэл намдаах, хаван хөөх, цистит үүсэх болон цистит дахихаас сэргийлэх үйлдэлтэй.



Ямар тохиолдолд хэрэглэвэл зохистой вэ?

- Бөөрний өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор
- Ажлын хүнд нөхцөл буюу хүйтэн, сэрүүн, чийгтэй орчинд ажилладаг хүмүүс
- Бөөрний эмчилгээний үед эмчилгээ дэмжих мөн эмчилгээний дараа гам барих зорилгоор
- Циститийн үед
- Бөөрний үрэвслийн үед



ХАР САРИМС

БИОЛОГИЙН ИДЭВХТ БҮТЭЭГДЭХҮҮН

Хар саримс



Биеийн дархлаа дэмжих, цусан дахь холестерин хэмжээг тогтворжуулах, харшлын шинж тэмдгийг бууруулах, хэт исэлдэлтээс /антиоксидант/ урьдчилан сэргийлэх, хавдар үүсгэгч эсийг дарангуйлах, бие махбодоос хорт бодисыг гадагшлуулах үйлдэлтэй.



Чихэр өвс

Харшил эсэргүүцэх, хавдрын эсийг бууруулах, шарх эдгэрэлтийг түргэсгэх, үрэвсэл намдаах үйлдэлтэй.



Ямар тохиолдолд хэрэглэвэл зохистой вэ?

- Зүрх судасны үйл ажиллагааг дэмжих зорилгоор
- Цусан дахь холестерин хэмжээг бууруулан биеийг хоргүйжүүлэх
- Дархлааны системийн үйл ажиллагааг дэмжих
- Хорт хавдрын өвчлөлөөс сэргийлэх
- Харшлын эсрэг үйлчилгээтэй учир харшлаас урьдчилан сэргийлэх
- Исэлдэлтийн эсрэг буюу антиоксидант үйлчилгээтэй учир эд эсийг нөхөн сэргээх
- Бие махбодын эрдэс бодисын хэрэгцээг хангах зорилгоор тус тус хэрэглэнэ.



БАРАГШУН АЛТАНГАГНУУР

БИОЛОГИЙН ИДЭВХТ БҮТЭЭГДЭХҮҮН



БАРАГШУН

Хүний бие махбодын хэвийн үйл ажиллагааг хангахад оролцдог натри, кали, кальци, төмөр, фосфор, магни зэрэг 30 орчим эрдэс бодис, 6 төрлийн амин хүчил агуулагддаг тул үе мөчний өвчин, ясны хугарал, бэртэнгийн үед эдгэрэлтийг түргэсгэх үйлдэлтэй.



АЛТАНГАГНУУР

Мэдрэлийн системийн үйл ажиллагааг дэмжих бие махбодын тамир тэнхээг сэргээх, ясны нөхөн төлжилтийг дэмжих, ясны бороололтыг түргэсгэх үйлчилгээтэй.



Өнгөр зоосон цэцэг

Ясны бэртэл, гэмтлийн үед үрэвсэл намдаах үйлдэлтэй.



Ямар тохиолдолд хэрэглэвэл зохистой вэ?

- Ясны хугарал, бэртэнгийн үед эдгэрэлтийг түргэсгэх зорилгоор
- Ясны сийрэгжилт болон ясны сийрэгжилтээс үүдэлтэй хугарлын үед
- Оюуны болон мэдрэлийн системийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор
- Бие махбодын тамир тэнхээг сэргээх зорилгоор
- Дархлаа дэмжих зорилгоор
- Эмийн болон мэс заслын дараах эмчилгээний үед эмчилгээг дэмжих, мөн эмчилгээний дараа гам барих зорилгоор



Хүүхдэг, багачуудгаа зориулсан бүтээгдэхүүнүүдгээ шинэчлэн гаргалаа

"Маамуу" цуврал хүүхэлдэйн киноны гол дүрийн өхөөрдөм баатруудын нэрээр бүтээгдсэн "Аами, Таами" шүүс төрлөө нэмэн тоорын амтат Таами&Жожо, чангаанз болон луувангийн амтат Аами&Өөдөө"-гөөр төрлөө нэмлээ. Мөн байгалийн зэрлэг жимсний агууламжтай аньс, нэрс, чацарганын үзэмтэй үрлүүдгээ шинэчлэн гаргалаа. Эдгээр бүтээгдэхүүныг хүүхэд багачууд өдөр тутамдаа хэрэглэснээр хоногийн С амин дэмийн хэрэгцээгээ бүрэн хангаж, дархлааг дэмжин ханиаднаас урьдчилан сэргийлэх боломжтой.



ХЭРЭГЛЭЭНД ХЯЛБАР САВЛАГАА ХVVХДИЙН ӨДРИЙН ВИТАМИН С-ИЙН ХЭРЭГЦЭЭГ ХАНГАНА.

BerryVit брэндийн байгалийн зэрлэг жимс буюу аньс, нэрс, чацарганатай үзэмтэй үрлүүдгээ шинэчлэн гаргалаа.



Монгол орны үржил шимт хөрсөнд ургадаг байгалийн зэрлэг жимс болох Аньс, Нэрс, Чацаргана жимсэнд агуулагдах олон төрлийн аминдэм, эрдэс бодисуудыг хүүхэд багачууддаа зориулан Берривит брэндийн витаминт, үзэмтэй, ааруултай гэсэн нэр төрлийн үрлийг үйлдвэрлэн гаргаж байна.

Берривит брэндийн үрлүүд нь Витамин С болон кальциар баялаг бөгөөд найрлагадаа химийн будагч бодис агуулаагүйгээрээ онцлогтой.

КОМПАНИЙН СОЁЛ, ХҮНИЙ НӨӨЦИЙН ӨСӨЛТ ХӨГЖИЛ



Манай ажилтан бүр Монос Хүнс компанийн үнэт зүйл, амжилтын үндэс суурь юм. Бид ажилтнуудынхаа ажиллах орчинг таатай байлгах, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, өрсөлдөхүйц цалин хөлсийг бий болгохоор зорин ажиллаж байна.



АЖИЛТНУУДЫН ДУНДАЖ НАС: 35

Уян хатан цагийн систем

Ажилтнуудын сурч хөгжих, хувь хүний хэрэгцээ, эрх ашгийг үндэслэн ажил эхлэх болон дуусах цагийг 4 төрлийн сонголттой болгосон.



Номын сан

Мөн ажилтнуудын танин мэдэхүйн хэрэгцээг хангах ажилчдын номын санг нээн ажиллуулж байна.



Эрүүл мэндийн үзлэг

Компанийнхаа нийт үндсэн идэвхтэй ажилтнуудынхаа эрүүл мэнд, сэтгэл ханамжийг дээшлүүлэх зорилготой урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан.



АНХНЫ ТӨРСӨН СЭТГЭГДЭЛ:

Монос Хүнс ХК-ийн нийт хувьцаа эзэмшигч, хэрэглэгчиддээ энэ өдрийн мэндийг дэвшүүлье.

Монос Хүнс компани одоогоос 3 жилийн өмнө буюу 2019 онд олон нийтэд хувьцаагаа санал болгож Монос Группийн анхны хувьцаат компани болсон түүхтэй. Тэр цагаас хойш миний бие Монос Хүнс ХК-ийнхаа Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгогдон ажилласан.

Анх олон нийтийн компани болох танилцуулгаа хийх үед одоогийн Шингэн хүнсний үйлдвэрийн зураг төсөл, шинээр гарах бүтээгдэхүүнүүдийн танилцуулгыг хараад хүлээлт өндөр байсан ч түүнийгээ дагаад энэ их ажлыг энэ цаг хугацаанд амжих болов уу гэсэн өөрийн зүгээс багахан зэргийн эргэлзээ, сандралттай байлаа.

Харин 3 жилийн дараах компанийн үйл ажиллагаа, гаргаж буй үр дүнг харахад Монос Хүнс компанийн хамт олон хувьцаа эзэмшигч, хэрэглэгч нартаа амласан амлалтдаа хүрч чадсан байна. Монгол улсын иргэдийн хүнсний хэрэглээнд урьдчилан сэргийлэх үйлдэлтэй биологийн нэмэлт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн хэрэглэгчдийн өдөр тутмын хэрэглээнд дадал бий болгож өвдөхөөсөө өмнө урьдчилан сэргийлэх соёлыг нэвтрүүлэн, үйл ажиллагаа жилээс жилд өсөн нэмэгдэж байгааг харахад бахархах сэтгэгдэл төрч байна. Мөн энэ цаг хугацаа хувьцаат компани болоод удаагүй компаниудын хувьд амар жил байсангүй.

Дэлхий нийтийг цочроогоод буй короновирусийн халдварын тархалт түүнийг дагаад удаан хугацааны хөл хорио, хил гаалийн хаалттай байдал зэрэг асуудлууд нь тус компани төдийгүй бусад бизнес эрхлэгчдэд хүндхэн сорилт, хязгаарлалт болж байлаа. Гэсэн хэдий ч компанийн сайн менежмент хариуцлагатай удирдлага, баг хамт олон хэлсэндээ хүрч өнөөдрийн амжилтыг бий болгож чадлаа. Тодруулбал, Монгол улсын цэвэр усны зах зээлд өөрийн байр суурийг эзэлж, тогтмол хэрэглэгчиддээ бий болгож чадсанд миний хувьд баяртай байна. Төгсгөлд нь Монос Хүнс ХК-ийн нийт хувьцаа эзэмшигчид, ажилтан хамт олон, хэрэглэгч нартаа 10 жилийн ойн баярын мэнд хүргэе.

ТУЗ-ийн хараат бус гишүүн
Аудитын хорооны дарга
Арг Лайф ХХК Гүйцэтгэх захирал

Б.Гантулга



МОНОС ХҮНС ХК-ИЙН ХЭТИЙН ЗОРИЛГО

Чанарын баталгаажуулалт

Монос Хүнс ХК нь 2019 онд Олон улсын чанарын удирдлагын тогтолцоо ISO-9001:2015 болон Хүнсний аюулгүй байдлын HACCP стандартын шаардлагыг бүрэн хангаж Олон улсын аудитын SGS компаниар баталгаажуулж үйл ажиллагаандаа амжилттай нэвтрүүлсэн. Бид бүхэн энэхүү чанарын тогтолцоогоо улам сайжруулж MNS ISO/IEC 17025:2018 стандартыг нэвтрүүлэх төслийг эхлүүлээд байна. Мөн Монос Хүнс ХК үйлдвэрийн хэмжээнд цахилгааны хэрэглээг багасгах, үйлдвэрлэлээс гарсан саарал усыг дахин ашиглах ажлуудыг хэрэгжүүлдэг. Үүнийгээ дагаад байгальд орчинд ээлтэй үйлдвэрлэл эрхлэх зорилтуудыг өдөр тутмын үйл ажиллагаандаа баримтлан ажиллаж байна. Уг үйл ажиллагаагаа баталгаажуулахын тулд Байгаль орчны менежментийн тогтолцоо ISO 14001:2016 төслийг эхлүүлээд байна.



Бүтээгдэхүүн хөгжүүлэлт-Байгальд ээлтэй хүнсний үйлдвэрлэл

Монос Хүнс ХК нь одоогоор эрүүл мэндийг дэмжсэн шингэн болон хуурай хүнсний чиглэлд үйлдвэрлэл явуулдаг. Бид цаашид өөрсдийн үйлдвэрлэж байгаа болон шинээр үйлдвэрлэхээр зорьж буй бүтээгдэхүүнээ хэрэглэгчдийн хэрэгцээнд илүү нийцүүлэх, олон улсын стандарт хангах, судалгаа шинжилгээнд суурилсан бүтээгдэхүүнийг экспортын зах зээлд гаргахаар тасралтгүй хөгжүүлсээр байх болно.

Хуурай хүнс чиглэл:

Энхжин эрүүл мэндийн цайны сав баглаа боодлыг хэрэглэхэд илүү хялбар болгохын зэрэгцээ ашиглагдаж байгаа цаас болон гялгар уутны хэрэгцээг багасгах замаар хог хаягдлыг бууруулахаар зорин ажиллаж байна.



Шингэн хүнс:

Хэрэглэгчдийн дунд түгээмэл тохиолдож байгаа өвчлөлүүдээс урьдчилан сэргийлэх, эмчилгээнд ашиглагддаг бүтээгдэхүүнийг хэрэглэгчдийн өдөр тутамд хэрэглэхэд хялбар байдлаар хөгжүүлэхээр зорин ажиллаж байна.

АНХНЫ ТӨРСӨН СЭТГЭГДЭЛ:

Тээвэр ложистик, санхүүгийн салбарт ажиллаж байсан надад хүнсний үйлдвэр цоо шинэ мэдрэмж, даалгавар болсон. Компанийн удирдлагууд, харилцагч, хөрөнгө оруулагч нарын хамт хэд хэдэн удаа үйлдвэртэй танилцах аялал хийх болгонд шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэлт, үйлдвэрлэлийн бодит дэвшилд бахархдаг.

Миний хувьд компанийн үйл ажиллагааны үр дүн, өгөөжийг тогтмол нээлттэй хийгддэг тайлан мэдээ, танилцуулга болон хувьцааны үнийн өсөлт, ТОП 20 ангилал, Монголын хөрөнгийн биржийн 1-р ангилал зэрэг үр дүнгээр үнэлдэг.

Мөн урирдлагын баг, инженер техникийн мэргэжилтнүүдийн тогтвортой, уйгагүй хичээл зүтгэлийн дүнд үйлдвэрийн хэмжээ, нэр төрөл нэмэгдэж гуравхан жилийн дотор шинэ шатанд гаргахаар дараагийн хөрөнгө оруулалтаа татаж байгаа нь гайхамшигтай амжилт юм. Энэ хамт олон, цар тахал хэмээх айхтар нэртэй нүүр тулсан хүнд бэрх хоёр жилийг эв нэгдэл сахилга баттайгаар даван гарч өмнө жилийнхээ амжилтыг жил бүр шинэчлээд явааг харж түүний өчүүхэн хэсэг болж яваадаа сэтгэл хангалуун байна.

**ТУЗ-ийн хараат бус гишүүн,
Тандем Глобал ложистик
Монголиа ХХК Гүйцэтгэх захирал**

Ч.Чинзориг



МОНОС ХҮНС ХК-ИЙН ХЭТИЙН ЗОРИЛГО



Экспортын чиглэл


Монос Хүнс ХК үндэсний брэндээ олон улсын зах зээлд таниулан, гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлж экспортод гаргадаг бүтээгдэхүүний нэр төрлөө өргөжүүлэхээр ажилладаг. Энэ хүрээнд одоогоор БНХАУ, АНУ, Өмнөд Солонгос улсад экспортын үйл ажиллагааг эхлүүлээд байна. Цаашлаад тухайн улс орон бүрийн хэрэглэгчдийн онцлогт нийцсэн бүтээгдэхүүнийг хөгжүүлэн, нийлүүлэхээр ажиллаж байна.

MFC
ҮЙЛДВЭР 2.0

ТӨСЛИЙН
ТАНИЛЦУУЛГА



Манай компани нь Хуурай болон шингэн хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж ирсэн бөгөөд энэ жил Монос Хүнс ХК-ийн 10 жилийн ой тохиож байна. Энэхүү түүхэн мөчид бизнесийн ирээдүйгээ тодорхойлох, хөгжлийн дараагийн үе шатад хөтлөх, хоёр үйлдвэрээ нэгтгэх үйлдвэрлэлийн "MFC 2.0" төслөө эхлүүлэх болсноо нийт хувьцаа эзэмшигч, хэрэглэгчид та бүхэндээ дуулгахад таатай байна.



MFC 2.0 Төслийн боломж болон давуу талууд:

- Үйлдвэрийн автоматжуулалт
- Үйлдвэрийн хүчин чадал нэмэгдэж халуун, хүйтэн савлагаа болон биологийн идэвхт бүтээгдэхүүний савлагааг нэгэн зэрэг үйлдвэрлэх
- Үйлдвэр-оффисын хосолмол шийдлийг бий болгох ажилтнуудын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх
- Үйл ажиллагаа өргөжиж, борлуулалтын орлого нэмэгдэх
- Шинэ брэнд бүтээгдэхүүнүүдээ зах зээлд амжилттай үйлдвэрлэн гаргах юм.

ТӨВ ОФФИС:

Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,
2-р хороо, Чингисийн өргөн чөлөө 205/2 тоот, 17043

ШИНГЭН ХҮНСНИЙ ҮЙЛДВЭР:

Монгол улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг,
20-р хороо, Үйлдвэрийн баруун бүс
Сонсголонгийн зам 32/3 тоот, 16103



www.monosfoods.mn



foods@monos.mn



MonosFoods



976-7777-3525